



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗРЫН ДАРГА Х.ХЭРЛЭН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,
<http://www.mmhi.gov.mn>

2018. 11. 22 № 03/3134
танай _____-ны № _____-Т

Албан даалгавар хүргэх тухай

Уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, гэрээлэгчид аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг даалгах тухай Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 5 дугаар албан даалгаврыг гаргасныг хавсралтаар хүргүүлж байна.

Чиг үүргийн дагуу харилцагч байгууллага, аж ахуйн нэгж, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүд болон гэрээлэгч нарт холбогдох албан даалгаврыг хүргүүлж, албан даалгаврын хэрэгжилтийг хангуулж ажиллана уу.

Хавсралт 1. хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Г.НАНДИНЖАРГАЛ



08 1832



МОНГОЛЫН ХАМГААГАХ
УЛАСЫН ТӨСВИЙН
УХААНИЙН ТАСАР
УХАА0505

Хэргийн №: ... Кэсгийн №: ...

Цэвэр ...

Шинэ ...

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 10 сарын 26 өдөр

№ 5

Улаанбаатар хот

Уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, гэрээлэгчид аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг даалгах тухай

1. Уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдүүд, гэрээлэгч /цаашид "үйлдвэрлэл эрхлэгчид" гэх/ нарын аюулгүй ажиллагааг хангаж ажиллах, үйл ажиллагаанаас бий болох хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг таслан зогсоох зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаас дараах арга хэмжээг авч ажиллахыг даалгаж байна. Үүнд:

1.1 Үйлдвэрлэл эрхлэгчид:

1.1.1 Үйлдвэрлэлийн шат дамжлагаас бий болж байгаа хог хаягдлыг дахин боловсруулах, хог хаягдал үүсгэхгүй байх дэвшилтэд технологийг ашиглахыг эрмэлзэх;


1.1.2 Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх, аюулгүй ажиллагааны болон аюултай хог хаягдлын талаарх хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг хангах;

1.2 Яамны уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн асуудал хариуцсан нэгжүүд болон Ашигт малтмал, газрын тосны газар:

1.2.1 Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны болон аюултай хог хаягдлын талаарх хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, зөрчил гаргасан үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагатай хамтран хяналт шалгалт явуулж, хуульд заасан хариуцлага тооцох;

1.2.2 Үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанаас бий болсон хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлсэн бол хохирлыг буруутай этгээдээр нөхөн тэлүүлэх, удаа дараа ноцтой зөрчил гаргаж, гаргасан зөрчлөө арилгахгүй байгаа үйлдвэрлэл эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийг хуульд заасан үндэслэлээр хүчингүйд болгох, цуцлах хүртэл арга хэмжээг авах;

2. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн явцыг тухай бүр танилцуулж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Одхүү/-т үүрэг болгосугай.



Д.СУМЬЯАБАЗАР